


Геронтологийн үндэсний төвийн ерөнхий
захирлын 2020 оны 07 дугаар сарын 07
өдрийн 164 тоот тушаалын 1 хавсралт



ШИНЭ АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмаар Геронтологийн үндэсний төв /цаашид төв гэх/-д ажилд орох эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтныг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Шинэ ажилтан сонгон шалгаруулах журам /цаашид журам гэх/ нь Монгол Улсын үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.

Хоёр. Сонгон шалгаруулалтыг мэдээлэл

2.1 Хүний нөөцийн менежер нь сул ажлын байрны талаар албадуудаас ирүүлсэн мэдээллийг байгууллагын веб хуудас болон бусад олон нийтийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд ил тод байршуулан сонгон шалгаруулалтын хугацаанд байршуулах

2.2 Мэдээлэлд тухайн ажлын байранд тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, хүлээн авах хаяг, харилцах утасны дугаарыг зааж өгсөн байна.

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцогчдын материалыг хүлээн авах

3.1 Хүний нөөцийн менежер нь сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэдээс дор дурдсан баримтыг бүрдүүлж хүлээн авна. Үүнд:

1. Анкет (Төрийн албан хаагчийн анкетийн дагуу)
2. Боловсролын диплом /хуулбар/
3. Иргэний үнэмлэх /хуулбар/

4. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ

3.2 Тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангаагүй болон энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг дутуу бүрдүүлж ирсэн иргэнийг сонгон шалгаруулалтад оруулахгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулах

4.1 Сонгон шалгаруулалтын эхний шатыг хүний нөөцийн менежер зохион байгуулж, тэнцсэн иргэдийн материалыг төвийн ерөнхий захиралд танилцуулна.

4.2 Тэнцсэн иргэдийн сонгон шалгаруулалтыг дараах бүрэлдэхүүнтэйгээр явуулна.

Үүнд:

1. Ерөнхий захирал /Комиссын ахлагч/
2. Хүний нөөцийн менежер /Комиссын нарийн бичиг/
3. Тухайн ажилтныг авах албаны дарга

4.3 Комиссын гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй байвал зохино. Хэрэв ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж үзвэл татгалзах үүрэгтэй.

4.4 Сонгон шалгаруулалтыг дараах шалгуураар дүгнэнэ.

1. Ерөнхий мэдлэг
2. Мэргэжлийн ур чадвар
3. Ёс зүй харилцаа хандлага
4. Ажлын туршлага
5. Ярилцлага
6. Биеэ авч яваа болон зүй зохистой хувцасласан байдал

Тав. Сонгон шалгаруулалтыг дүгнэх

5.1 Сонгон шалгаруулалтын дүнг комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Уг хурлын шийдвэрийг үйлдэж комиссын дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.

5.2 Сонгон шалгаруулалтын дүнг оролцогчдод Хүний нөөцийн менежер мэдэгдэж ажилд орох өдрийг товлон.

5.3 Байгууллагын дарга шалгаруулалтад тэнцсэн иргэнтэй хөдөлмөрийн гэрээг байгуулснаар сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дуусна.

5.4 Удирдах албан тушаалд Шинээр томилогдохоор шалгарсан ажилтны Ашиг сонирхлын зөрчлийн урьдчилсан мэдүүлгийг авлигатай тэмцэх газарт хүргүүлж саналыг авсны үндсэн дээр томилно.

Зургаа. Бусад зүйл

6.1 Сонгон шалгаруулалтын явцыг баримтжуулсан материалыг хүний нөөцийн менежер 4-н жил хадгална.

6.2 Сонгон шалгаруулалтад дараагийн шаардлага хангасан ажил горилогчдын материалыг нөөцөд авч 2 жил хадгална.

*

*

*

ХӨЛСӨӨР АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2024.08.08

Нэг талаас Геронтологийн үндэсний төвийн ерөнхий захирал Р.Хишигжаргал /Цаашид ажиллуулагч гэх/ нөгөө талаас ИЭ73031237 регистрийн дугаар бүхий Эрхэмбаяр овогтой Батаа /Цаашид ажиллагч гэх/ нар харилцан тохиролцож Иргэний хуулийн 359-368 дугаар зүйлийг үндэслэл болгон энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний үндсэн нөхцөл

- 1.1 Ажиллагч нь Геронтологийн үндэсний төвд Жолооч / аж ахуй, засвар үйлчилгээ, цахилгаанчин, сан техникийн слесарь, /-н үүргийг гүйцэтгэнэ.
- 1.2 Энэхүү гэрээний хугацаа нь 2024 оны 08 дугаар сарын 08-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 31-ийг хүртэл байна.
- 1.3 Ажиллагчийн сарын ажлын хөлс нь 900000 /есөн зуун мянга/-н төгрөг байна.
- 1.4 Ажлын хөлсийг сарын сүүлд Хаан банкин дахь 5024557311 тоот дансанд шилжүүлнэ.
- 1.5 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах, асуудлыг талууд харилцан тохирч бичгийн хэлцэлээр шийдвэрлэнэ.
- 1.6 Талууд харилцан тохиолцоогүй асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 1.7 Гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх тохиолдолд харилцан тохирч өөрчлөлт оруулна.
- 1.8 Гэрээг харилцан тохиролцож сунгаж болно.

Хоёр. Жолооч ажилтаны эрх үүрэг

- 2.1 Жолооч ажиллагч нь 7 хоногт 2 удаа /Даваа, Пүрэв гарагт/ ирж байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.
- 2.2 Ажиллагч нь гүйцэтгэсэн ажлын тайлангаа сар бүр Стратеги төлөвлөлтийн албаны даргад хүргүүлнэ.
- 2.3 Жолооч ажиллагч нь төвийн байранд 7 хоногт хоёр удаа ирж 8 цагаар ажиллана. Бусад үед шаардлагатай тохиолдолд дуудагдаж ажиллана.
- 2.4 Автомашины хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, ажилд гарах бүртээ автомашины бүрэн бүтэн байдлыг нягтлан шалгаж гарна.
- 2.5 Автомашиныг зориулалтын бус тээвэрт ашиглахгүй байх
- 2.6 Зорчигчийн эрүүл аюулгүй зорчих нөхцөл бололцоог хангах
- 2.7 Төвийн байрны дулаан, цахилгааны засварыг хийх
- 2.8 Төвийн байранд сан техникийн слесарийн ажлийг хариуцаж ажиллах
- 2.9 Төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө, албаны төлөвлөгөөнд аж ахуйтай холбоотой ажил төлөвлөх гүйцэтгэлийг хангаж ажиллах
- 2.10 Төвийн нярав, нягтлан бодогч нарт холбогдох санхүүгийн анхан шатны баримтыг хугацаанд өгөх, тайлагнах

2.11 Төвийн байрны засвар үйлчилгээг хариуцаж ажиллах

2.12 Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцох

2.13 Харилцан тохиролцсоны үндсэн дээр удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь чанартай гүйцэтгэх

2.14 Шаардлагатай тохиолдолд гэрээнд заасан хугацаа харгалзахгүйгээр байгууллагын үйл ажиллагааг алдагдуулахгүйн тулд удирдлагаас дуудаж ажиллуулах

Гурав. Геронтологийн үндэсний төвийн эрх үүрэг

3.1 Геронтологийн үндэсний төв нь гэрээний дагуу ажлын хөлс болох 900.000 төгрөгийг тооцож сар бүр олгох үүргийг хүлээнэ.

3.2 Гэрээт ажилтны нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварыг хариуцаж төлөх

3.3 Жолооч ажилтныг ажлын байр болон компьютер техник хэрэгслээр хангах үүрэгтэй.

Дөрөв. Талуудын хариуцлага

4.1 Геронтологийн үндэсний төв нь Жолоочийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хөлсийг бууруулах буюу бүрэн хасах эрхтэй.

4.2 Жолооч ажиллагч нь Геронтологийн үндэсний төвд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд өөрт учирсан хохирол, дутуу төлөгдсөн хөлсөө нэхэмжлэн авах эрхтэй.

4.3 Хоёр тал үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцсоны үндсэн дээр эвийн журмаар шийдвэрлэнэ.

4.4 Маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.5 Гэрээний хугацаа дуусахаас өмнө ажиллагч гэрээний үүргийг хангалтгүй биелүүлж буй тохиолдолд гэрээний явцын үнэлгээ хийж болох бөгөөд тухайн үнэлгээг үндэслэн ажиллуулагч нь гэрээнээс татгалзах, эсхүл гэрээг цуцлах асуудлыг хэрэгжүүлж болно.

4.6 Аль нэг тал нь гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь гэрээг шууд дуусгавар болгож болно.

4.7 Гэрээг аль ч талийн санаачлагаар харилцан тохиролцож энэхүү гэрээний 1.2-т заасан хугацаанаас өмнө дуусгаж болно.

Тав. Гэрээ дуусгавар болох

5.1 Гэрээ нь 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болно.

Гэрээ байгуулсан:

ЛҮГ-ийн Захирал

Р. Хишигжаргал

Сүхбаатар дүүрэг, 11-р хороо Цагдаагийн

гудамж, Геронтологийн үндэсний төв байр

Утас: 11350801

Жолооч



Э.Батаа

СХ дүүрэг, 6-р хороо

тоосогны 13 - 263 тоот

Утас: 88136409